

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/		2026 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2026 оны 6-р сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		Премииум Нэксус ХК УБ-ийн дугаар 9007001006 ҮЦ-ны код CUMN Утас 976-7733-0101
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын Хөрөнгийн Бирж ХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Хүнсний дэлгүүр; Хүнсний үйлдвэрлэл; Худалдааны зуучлал; Франчайзын гэрээний үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах; Гадаад худалдаа; Менежментиин зөвлөх үйлчилгээ
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		1,114,252,034 ширхэг энгийн хувьцаа
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн: Б.Ганзориг, Санхүү хариуцсан захирал Хянасан: Г.Чинзориг, Гүйцэтгэх захирал
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Нийт хөрөнгө : 487,076,140 мянган төгрөг Нийт өр төлбөр : 373,029,495 мянган төгрөг Эздийн өмч : 114,046,645 мянган төгрөг
	Орлогын тайлан	Борлуулалтын орлого : 430,750,391 мянган төгрөг Нийт ашиг : 53,831,766 мянган төгрөг Татварын дараах цэвэр ашиг: 6,689,753 мянган төгрөг
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Хувьцаат капитал: 111,425,203 мянган төгрөг Халаасны хувьцаа: (7,635,974) мянган төгрөг Нэмж төлөгдсөн капитал: 28,272,936 мянган төгрөг Эздийн өмчийн бусад хэсэг 318,731 мянган төгрөг Хуримтлагдсан ашиг/(алдагдал) : (36,800,557) мянган төгрөг Хяналтын эрхгүй хувь оролцоо: 18,466,306 мянган төгрөг
	Мөнгөн гүйлгээний тайлан	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал : 58,309,773 мянган төгрөг Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал : (50,437,549) мянган төгрөг Санхүүжилтийн цэвэр мөнгөн урсгал : (9,067,681) мянган төгрөг

2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт		
	Энэ маягтад хавсаргав.		
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт		
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Цэвэр ашгийн хувь Нийт хөрөнгийн өгөөж (ROA) Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж (ROE) Нийт хөрөнгийн эргэц (ROTA) Нэгж хувьцааны өгөөж (EPS) Үнэ ашгийн харьцаа (P/E ratio)	1.55 % 1.45 % 5.86 % 5.09 % 6.00 44.26
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа Түргэн хөрвөх чадварын харьцаа	0.60 0.13
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	2026 оны эхний хагас жилд нийт салбарын тоог 68-ээр нэмэгдүүлж 603 салбартай болоод байна. Үүнээс 15 аймагт 112 салбар дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна. Ингэснээр орон нутагт: - Хүнсний аюулгүй байдлыг хангасан ОУ-ын стандартад нийцсэн үйлчилгээг үзүүлж, - Аялал жуулчлал, үйлчилгээний дэд бүтцийг сайжруулж - Шинээр ажлын байр бий болгож - Орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллаж байна. СУ-ийн бизнесээс гадна Премиум Нэксус ХК нь "СУ төвтэй бизнесийн экосистем"-ийг бүрдүүлэн бизнесийн цар хүрээгээ өргөтгөн ажиллаж байгаа нь үр дүнгээ өгч байна. Монголын ТОП 100 аж ахуйн нэгжийн жагсаалтад 7-р байранд эрэмбэлэгдэв.	
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Байхгүй	
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/		
	— Сонирхлын зөрчилтэй хэлцэл: ТУЗ-ийн 2026 оны 03-р сарын 26-ны өдрийн 7 тоот тогтоолоор ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг үндэслэн Компанийн зэргэлдээ компани болох Юу Эм Эс ХХК-ийн нэр дээрх Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 11-р хороо, Ургах наран хаягт байрлах, нэгж талбарын 1333114195 дугаартай, улсын бүртгэлийн Э-2204046147 дугаартай, үйлдвэрлэлийн барилга, байгууламж,		


	бусад газар зориулалт бүхий 51,723 м.кв газрын эзэмших эрхийг нийт 1,361,000,000 (нэг тэрбум гурван зуун жаран нэгэн сая) төгрөгөөр Компанийн нэр дээр шилжүүлж авах сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсөн. Уг хэлцэл нь тус газрын эзэмших эрхийг Компанийн нэр дээр шилжүүлэн бүртгүүлэх зорилготой бөгөөд сонирхлын зөрчилтэй этгээд нь Компанийн зэргэлдээ компани болох Юу Эм Эс ХХК болно. – Их хэмжээний хэлцэл: Их хэмжээний хэлцэл байхгүй
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл – Тайлант хугацаанд нэмж хувьцаа гаргах замаар олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлээгүй.
6.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл 1. ТУЗ-ийн 2026 оны 02-р сарын 10-ны өдрийн 2 тоот тогтоолоор Компанийн 2025 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэж, уг шийдвэр, түүний шалтгааныг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахаар шийдвэрлэсэн. 2. ТУЗ-ийн 2026 оны 03-р сарын 13-ны өдрийн 5 тоот тогтоолоор зарлан хуралдуулсны дагуу 2026 оны 04-р сарын 28-ны өдөр хуралдуулах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулж, Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг баталж, Компанийн 2025 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэр, түүний шалтгааныг танилцуулахыг шийдвэрлэсэн. 3. ТУЗ-ийн 2026 оны 06-р сарын 30-ны өдрийн 25 тоот тогтоолоор ТУЗ-ийн гишүүн Г.Бат-Эрдэнэ-г үүрэгт ажлаас нь чөлөөлж, ТУЗ-ийн гишүүний нөхөн сонгууль хүртэлх хугацаанд Н.Энхболдыг ТУЗ-ийн гишүүнээр түр томилж, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, БОНЗ хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. 4. ТУЗ-ийн 2026 оны 06-р сарын 30-ны өдрийн 24 тоот тогтоолоор Компанийн эрх бүхий албан тушаалтан болох Санхүү хариуцсан захирал Г.Бат-Эрдэнэ-г үүрэгт ажлаас нь чөлөөлж, Санхүү хариуцсан захирлын албан тушаалд Б.Ганзориг-ийг томилсон.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Г.Чинзориг Албан тушаал: Премиум Нэксус ХК-ийн Гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/тэмдэг)	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	

Овог, нэр: Б. Ганзориг

Албан тушаал: Премиум Нэксус ХК -ийн Санхүү хариуцсан захирал

Гарын үсэг:

ПРЕМИУМ НЭКСУС ХК



2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ИРЭЭДҮЙГ ЧИГЛЭСЭН МЭДЭГДЛИЙН ТАЛААРХ АНХААРУУЛГА


Премиум Нэксус ХК нь энэхүү тайланд “ирээдүйг чиглэсэн” зарим мэдэгдэл агуулагдсан болно. Тухайлбал, тус тайланд “бид таамаглаж байна, бид тооцоолж байна, бид зорьж байна, бид төлөвлөж байна” гэх мэт үгстэй ойролцоо үг, мөн ирээдүй цагийг илэрхийлэх үгс ашиглагдсан болно.Ирээдүйг чиглэсэн мэдэгдэл нь ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлын баталгаа биш бөгөөд бидний таамагласан нөхцөл байдал биелэхгүй байх магадлалтай ба тэдгээр таамаглалуудад хэт найдах нь учир дутагдалтайг анхаарна уу.

Компанийн бизнесийн үйл ажиллагааны цаашдын чиг хандлага нь эрсдэл, тодорхойгүй байдал гэх мэт хүчин зүйлс, мөн үүгээр хязгаарлагдахгүй зүйлсээс хамаарч материаллаг зөрүүтэй байж болно. Тиймээс, эдгээр эрсдэл болон тодорхойгүй байдлыг харгалзан үзэж ирээдүйг чиглэсэн мэдэгдэл, төсөөллийг шууд утгаар нь бодитоор биелнэ хэмээн авч үзэх нь өрөөсгөл юм. Мөн, компанийн зүгээс шинэ мэдээ мэдээлэл болон ирээдүйд гарах ялгаатай үр дүн эсвэл аливаа бусад шаардлагын улмаас энэхүү тайланд тусгагдсан ирээдүйд чиглэсэн таамаглалуудыг шинэчлэх эсвэл засварлах аливаа үүрэггүй болохыг мэдэгдэж байна.

Агуулга


• Компанийн тухай	03
• CU Конвиниенс дэлгүүр	06
• 2026 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд	09
• Нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлтүүдийн товч танилцуулга	19
• Хувьцааны ханшийн хөдөлгөөн	23

ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН УДИРДЛАГА



Компанийн тухай

ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН БИЗНЕСИЙН БҮТЭЦ



Компанийн тухай

Премиум Нэксус ЭКОСИСТЕМ Ба Түүний Давуу Талууд

Олон улсын стандартад нийцсэн хоол

Хоолны бүтээгдэхүүний гинжин хэлхээний бүх үе шатанд олон улсын стандарт, шилдэг туршлагад суурилсан хүнсний аюулгүй байдал, чанарын хяналтыг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд үндэсний үйлдвэрлэгчид НАССР баталгаажуулалтад хамрагдаж, салбарын стандартыг шинэ түвшинд хүргэн, зах зээлд манлайлах боломж бүрдэж байна.

Байгал орчин, Нийгэм, Засаглалын өндөр стандарт өргөн цар хүрээ

CU сүлжээ дэлгүүрийн ханган нийлүүлэгчид, ялангуяа жижиг дунд үйлдвэрлэгчид энэхүү эко-системд нэгдсэнээр, Премиум Нэксус ХК-ийн олон улсын жишигт нийцсэн БОНЗ-ын практикийг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

Логистик болон нэгдсэн түгээлтийн үр ашиг

Монголын дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдалд бүтээгдэхүүний нийт өртгийн 30 орчим хувийг логистикийн зардал эзэлж байгаа нь дэлхийн дунджаас 2-3 дахин өндөр үзүүлэлт юм. Премиум Нэксус нь логистикийн дэд бүтцийн сайжруулалт хийснээр дээрх үр ашиггүй байдлыг арилгах болно.

Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж

CU сүлжээ дэлгүүр үйлдвэрлэгчидтэйгээ хамтран бүтээгдэхүүн хөгжүүлснээр хэрэглэгчдийн хэрэгцээнд бүрэн нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж бүрдэнэ. Ингэснээр хэрэглэгчийн сэтгэл ханамжийг өндөр түвшинд хүргэх, үнэнч хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжтой.

Хөрөнгө оруулагчдын нэгдмэл ашиг сонирхол

CU сүлжээ дэлгүүрийг түшсэн, түүнтэй хамаарал бүхий бизнесүүдийг нэг дор нэгтгэснээр тэдгээр бизнесүүд хамтын хүчээр үлэмж үнэ цэнийг бий болгох боломжтой. Ингэснээр хөрөнгө оруулагчид энэхүү синергээс бий болох бүх боломжийг хүртэх нөхцөл бүрдэнэ.

Ажилтнуудын өсөж дэвших боломж, сэтгэл ханамж

Монголын томоохон хөрөнгө оруулалтын компанийн нэг хэсэг болж ажиллах, групп компани дотроо өсөж хөгжих, Премиум туршлагаас суралцах зэрэг боломжууд ажилтнуудад нээлттэй болно.

CU Конвиниенс дэлгүүр

ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

Хамгийн их сүлжээ дэлгүүртэй

2025 оны Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгж #7

Тэргүүлэгч жижиглэн худалдааны компани

Зах зээлийн үнэлгээ: 296 тэрбум төгрөг



Нэгтгэсэн нийт цэвэр борлуулалт
430+ тэрбум төг



Дэлгүүрийн тоо
603



Ажиллагсдын тоо
5,000~



Өдрийн дундаж
хэрэглэгчдийн тоо
200,000+



Хамтран ажиллагч байгууллагууд
400+



Хувьцаа эзэмшигчид /давхардсан тоогоор
10,211




+603 Дэлгүүрүүд
4,000~ Дэлгүүрийн ажилтнууд

CU Конвениенс дэлгүүр

CU КОНВЕНИЕНС ДЭЛГҮҮРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

Үйлчлүүлэгчдийн тоо (сая)




Дэлгүүрийн тоо

	2025H1	2026H1	Өссөн дүн
УБ	417	491	+74
Орон нутаг	80	112	+32
Нийт	497	603	+91

Ажиллагсдын тоо



Дэлгүүрийн тоо



*Ажилласан хүний тоо буюу тухайн тайлант хугацаанд төлсөн нийгмийн даатгал төлөгчдийн тоо давхардаагүй дүнгээр.

CU Конвиниенс дэлгүүр

CU ХАРЬЦУУЛСАН БОЛОН НИЙТ ДЭЛГҮҮРИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэл

2025 болон 2026 оны эхний хагас жилд бүтэн үйл ажиллагаа явуулсан 487 дэлгүүрийн гүйцэтгэлийг харьцуулсан болно. Эдгээр дэлгүүрийн 2025 болон 2026 оны өдрийн дундаж үзүүлэлтүүдийг харьцуулахад үйлчлүүлэгчдийн тоо 3.3%-иар, өдрийн дундаж борлуулалт 1.7%-иар тус тус өсөж, худалдан авалтын дундаж сагсны дүн 1.6%-иар буурсан байна.

Нийт дэлгүүрийн гүйцэтгэл

Харин уг үзүүлэлтийг бүх дэлгүүрийн хэмжээнд буюу 2025 оны эхний хагас жилд ажиллаж байсан 497 дэлгүүр (хаагдсан дэлгүүрийг хамруулан тооцсон), 2026 оны эхний хагас жилд ажилласан 603 дэлгүүрийн хувьд тооцож үзэхэд өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тоо 3%-иар буурч, дундаж сагсны дүн 1.9%-иар өссөнөөр өдрийн дундаж борлуулалт 2 хувиар буурчээ.

Хурдтай нэмэгдэж буй шинэ дэлгүүрүүд нь бойжилтын хугацаанаас үүдэн системийн нийт дэлгүүрийн өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тоог бууруулдаг тул харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэлээр дэлгүүрийн өсөлтийг хэмждэг.

Харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэл

	2025H1 -> 2026 H1
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	1.7%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	3.3%
Сагсны үнийн өсөлт	-1.6%

Харьцуулсан дэлгүүрийн тоо: 487

Нийт дэлгүүрийн гүйцэтгэл

	2025H1 -> 2026 H1
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	-2.0%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	-3.0%
Сагсны үнийн өсөлт	1.9%

Нийт дэлгүүрийн тоо: 497 → 603


2026 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮР

Онцлох үйл явдлууд

- 68 шинэ дэлгүүр нээж, 10 дэлгүүр хааснаар нийт 603 дэлгүүртэй болсон.
- Улаанбаатар хотод 491, орон нутагт 112 дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна.
- Нийт 16 аймагт хүрээгээ тэлсэн.

	2025	2026H1
CU дэлгүүрийн тоо	545	603



CU Конвиниенс дэлгүүр нь Монгол орныг зорин ирэх жуулчид болон нутгийн иргэдэд олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг хүргэхээр Улаанбаатар хотоос алслагдмал аймгууд болох Хөвсгөл, Баянхонгор, Дорнод аймгуудад шинээр салбар дэлгүүрээ нээн Монгол орны 16 аймагт үйл ажиллагаа явуулж байна. CU конвиниенс дэлгүүр нь үйл ажиллагаагаа Монгол орон даяар амжилттай тэлснээр бүс нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж, шинээр ажлын байрууд бий болгохын зэрэгцээ орон нутгийн иргэд, байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлж, хөгжил дэвшлийг хамтдаа бүтээх боломж бүрдэж байна.

2026 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮР

ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН



- ХӨВСГӨР -

Хөвсгөр бууз, ороомгийн чанарыг сайжруулж, **ХӨВСГӨР** брэндийг дахин нэвтрүүллээ.



- ИЛҮҮ ТОМ ХАЗ- ХОТДОГ -

Бидний онцлог, брэнд бүтээгдэхүүнүүдийн нэг болох Хотдогийг бүтнээр нь шинэчлэн илүү том, илүү амттай болгож дахин танилцууллаа.



- МОНГОЛ АМТЫГ CU-с -

Таван цулын мах болон хоньны махаар хийсэн Монгол уламжлалт амт бүхий бүтээгдэхүүний цувралыг бүх салбарт нэвтрүүлэв.



- GET Morning -

GET кофетай төгс тохирох, өглөөний цайны сонголт GET Morning бүтээгдэхүүнүүд шинээр зах зээлд нэвтрүүлэв.

2026 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮР

ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН



-K-BEAUTY

Арьс арчилгаагаараа алдартай Солонгосын **Tony Moly** брэндтэй хамтран гаргасан салфеткан маскыг зөвхөн Монголын CU-д борлуулж эхэллээ.



-Real Smoothie -

Жинхэнэ жимсээрээ, нэмэлтгүй шинэхэн смүүтиг 30 салбараас авах боломжтой боллоо. Эрүүл бөгөөд тренди бүтээгдэхүүний цоо шинэ төрөл нэмэгдлээ.



- ГЭРИЙН ХҮНС -

Жижиг савлагаатай CU нэрийн хүнсний бүтээгдэхүүнүүд төрлөө нэмсээр байна. Өндөг, сэндвич талх, сэндвич хам зайдас зэрэг илүү өргөн сонголтыг CU-н салбаруудаас авч хэрэглээгээ хялбарчлах боломжтой боллоо.



- CU нэрийн ус -

CU Нэрийн, салдаггүй тагтай анхны савласан цэвэр усыг Монос Хүнс ХК-тай хамтран бүх салбараар нэвтрүүлж байна.

2026 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

Монгол Улсын ТОП-100 аж ахуйн нэгжээр 6 дахь удаагаа шалгарч 7 дугаар байрт эрэмбэлэгдэв



Манай компани Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгжээр 6 дахь жилдээ шалгарч, үндэсний тэргүүлэгчдийн эгнээнд буюу 7-р байранд 2 жил дараалан эрэмбэлэгдлээ. Бид даатгуулагчдын тоогоор улсдаа 2-рт жагсаж, Монгол Улсын хэмжээнд хамгийн олон ажлын байр бий болгогчдын нэг болж, бизнесийн үйл ажиллагаагаараа дамжуулан нийгэмдээ үнэ цэн бүтээж байгаадаа баяртай байна. Хэдийгээр бид бизнесийн салбарт залуу компани ч гэлээ, анх 2017 онд үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш улсын төсөв болон нийгмийн даатгалын санд нийт 121.1 тэрбум гаруй төгрөгийг төвлөрүүлээд байна. Үүнээс зөвхөн 2025 онд л гэхэд татвар, нийгмийн даатгалын шимтгэлд 42.6 тэрбум гаруй төгрөг төлж, улс орныхоо эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулсаар байна.

2026 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

Монголын анхны “Ногоон өртөө” СУ-ийн 600 дахь салбар нээлтээ хийлээ



“Премиум Нэксус” ХК СУ конвиниенс дэлгүүрийн 600 дахь салбараа Булган аймгийн Хутаг-Өндөр суманд нээж, Монголын анхны “Ногоон өртөө” жишиг дэлгүүрийг ашиглалтад орууллаа. 100 хувийн өөрийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулсан тус салбар нь нарны эрчим хүчний шийдэл, цахилгаан автомашин цэнэглэх станц, аялагчдад зориулсан шүршүүрийн үйлчилгээ, чанартай халуун хоол зэрэг зам дагуух иж бүрэн үйлчилгээг нэг дор бүрдүүлэв. Мөн салбарын дэргэд орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих “Бизнес хөгжлийн төв” байгуулсан бөгөөд энэ нь бүс нутгийн эдийн засгийн хөгжил, тогтвортой хөгжлийг дэмжих шинэ бүтээн байгуулалт болж байна. СУ 600 дахь салбар нь тоон өсөлтөөс гадна ногоон хөгжил, аяллын соёл, орон нутгийн хөгжлийг нэгтгэсэн шинэ үеийн үйлчилгээний жишиг загвар болж буйгаараа онцлог юм.

2026 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

Азийн Хөгжлийн Банк үр ашигтай, хүртээмжтэй хүнсний түгээлтийг дэмжих нийгмийн зээлийн гэрээнд гарын үсэг зурлаа



Азийн Хөгжлийн Банк (АХБ) болон Премиум Нэксус ХК орчин үеийн жижиглэн худалдааны дэд бүтцийг хөгжүүлэх, хөргөлттэй логистикийн сүлжээг бэхжүүлэх, Монгол орон даяар ая тухтай дэлгүүрийн сүлжээг өргөжүүлэх замаар боломжийн үнэтэй, аюулгүй хүнс болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх 10 сая ам.долларын (35.8 тэрбум төгрөгтэй тэнцэх) нийгмийн зээлийн гэрээнд гарын үсэг зурлаа. Энэхүү түншлэл нь зөвхөн санхүүжилт бус, Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдал болон эдийн засгийн хүртээмжтэй өсөлтөд оруулж буй хөрөнгө оруулалт юм

2026 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

СЭНТРАЛ КОММЕРС ХХК




ASAHI SUPER DRY X MANCHESTER CITY

Asahi Supder Dry шар айраг нь Английн Manchester City хөлбөмбөгийн багтай хамтран ажилладаг ба Сэнтрал Коммерс ХХК нь Монголдоо анх удаа Manchester City кампанит ажлыг хэрэгжүүлж дууслаа. Энэхүү кампанит ажлын хүрээнд олон төрлийн идэвхжүүлэлтүүд хийгдэж байгаагийн нэг нь 4 хэрэглэгчийг Английн Манчестер хотын Этихад стадионоос Premier League тоглолтыг үзэх эрхтэй сугалаат худалдаа юм.

Кампанит ажлын хүрээнд Монгол Улсад дараах идэвхжүүлэлтүүд хэрэгжүүлж дууслаа:

- Asahi Super Dry х ManCity тусгай мерч бүтээгдэхүүнүүд
- Сугалаат худалдаа: Анлийн Манчестэр хотод Premier league тоглолт үзэх эрх - 4 хүн
- Erling Haaland-ын гарын үсэгтэй Manchester City багийн өмсгөл
- Сугалаат болон урамшуулалт хөтөлбөрүүд



CHINGGIS BRONCOS - ЧИНГИСИЙН ХҮЛЭГҮҮД

Монголын Сагсан бөмбөгийн 10 удаагийн дархлагдсан аварга “Хүлэгүүд” багтай Chinggis Beer брэнд хамтын ажиллагаагаа амжилттай эхлүүллээ. Хүлэгүүд баг Азийн BCL (Basketball Champions League) тэмцээнд "CHINGGIS BRONCOS" нэрийн дор амжилттай оролцлоо. Түүхээр овоглож тивд довтлох хамтралыг гурван арванаар холбосон ойгоо угтан түүхийн нэгэн хуудсыг бичилцсэн билээ.

Энэхүү хамтын ажиллагаагаар дамжуулан Chinggis Beer үндэсний спорт, багийн спортыг дэмжих, залуу үеийг идэвхжүүлэх нийгмийн хариуцлагын санаачилгаа амжилттай хэрэгжүүлсэн.



KOZEL БРЭНД МОНГОЛД

Сэнтрал Коммерс ХХК нь Чех улсын 150 гаруй жилийн түүхт Kozel брэндийг Монголын зах зээлд албан ёсны эрхтэйгээр худалдаанд гаргалаа.

Хэрэглэгчдэд зөвхөн шар айраг бус, шинэ амт, шинэ туршлага, өвөрмөц хэрэглээний соёлыг түгээдгээрээ онцлогтой.

•**Kozel Mix** нь Kozel Dark болон Kozel Premium Lager төрлүүдийг хослуулан өөрийн хүссэн амтыг бүтээх боломжийг олгодог.

•**Kozel Cinnamon Crust** аргаар Kozel Dark төрлийг Sweet Cinnamon Powder-тай хослуулснаар өвөрмөц зөөлөн бөгөөд шинэлэг амтыг мэдрэх боломжтой юм. "Амтаа бүтээ, Өөрөөр мэдэр" уриа дор Kozel брэнд нь хэрэглэгч бүрд өөрийн дуртай амтыг бүтээж, хором мөч бүрийг илүү хөгжилтэй, дурсамжтай өнгөрүүлэх боломжийг бүрдүүлж байна.

2026 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

ЧИНГИС ШАР АЙРАГ ХХК



2026 оны эхний хагас жилд Чингис Шар Айраг ХХК-ийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа тогтвортой, тасралтгүй явагдаж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн бүтээгдэхүүний чанар, стандартын шаардлагыг хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд бүтээгдэхүүний чанарын хяналтыг тогтмол хэрэгжүүлж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэхэд анхааран ажилласан.



Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) шаардлагыг чанд мөрдөж, ажилтнуудын аюулгүй ажиллах орчныг бүрдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тогтмол зохион байгууллаа. Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дотоод сургалт, ажлын байрны зааварчилгаа, мэргэжлийн сургалтыг төлөвлөгөөний дагуу тогтмол хэрэгжүүлсэн.

Үйлдвэрлэлийн өдөр тутмын үйл ажиллагааны уялдаа холбоо, ажлын зохион байгуулалт, бүтээмжийг сайжруулах чиглэлээр тасралтгүй ажиллаж, бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн сахилга бат, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэхэд онцгойлон анхаарсан.

Цаашид үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангах, бүтээгдэхүүний чанарыг тасралтгүй сайжруулах, үйл ажиллагааны үр ашиг болон бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны соёлыг улам төлөвшүүлэх чиглэлээр төлөвлөгөөт ажлуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2026 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

Сэнтрал Кофе Рөүстинг ХХК



“Сэнтрал Кофе Рөүстинг” ХХК нь 2026 оны эхний хагас жилд “Origin” брэндийг сурталчлах, борлуулалтыг өсгөх чиглэлээр HoReCa сувгууд болон Nomin, CU, Carrefour г.м жижиглэн борлуулалтын сувгуудаар дамжуулан хамтарсан компанит ажлууд буюу сошиал медиа хөгжүүлэлт, эвент зохион байгуулах, амталгаат худалдаа, борлуулалтын цэг дээрх POSM материал, дизайн гаргах зэрэг ажлуудыг амжилттай хэрэгжүүлээд байна.

Түүнчлэн аялал жуулчлалыг нэмэгдүүлэх, үндэсний онцлогийг шингээсэн кофе брэндийг таниулах үүднээс “Go Mongolia” төслийг эхлүүлээд байна. Уг төслийн хүрээнд үндэсний хэв маягийг шингээсэн шинэ савлагаа дизайн болон олон нийтэд чиглэсэн сошиал пост, видео контент, танилцуулга, POSM материал, гондола байршуулалт зэргийг хийгээд байна.

Мөн бид “Origin” брэндийн цаашдын өнгө төрх, хэв маягийг илэрхийлэх үндсэн шийдэл болох “Key visual”-ыг бэлтгэн гаргасны дагуу шинэ дизайн, мэрч бүтээгдэхүүнүүдийг гаргалаа.

2026 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд


СТОРА ЦЕНТРАЛ ХХК

Стора Централ ХХК 2026 онд хэрэглэгчдийн онлайн худалдан авалтын туршлагыг сайжруулах, захиалгын үйл явцыг илүү хурдан, хялбар болгох зорилгоор платформыаа үндсэн функцуудыг шинэчиллээ.

Шинэчлэлийн хүрээнд хэрэглэгчид хамгийн өндөр эрэлттэй бүтээгдэхүүнүүдийг нэг дороос харах, мөн өмнөх худалдан авалтын түүхдээ үндэслэн хувь хүнд тохирсон бүтээгдэхүүний санал зөвлөмж авах боломжтой болсон. Үүний зэрэгцээ системийн интерфэйсийг илүү ойлгомжтой, хэрэглэгчдэд ээлтэй байдлаар шинэчилснээр бүтээгдэхүүн хайх, сонгох, захиалах үйл явцын үр ашиг, ашиглахад хялбар байдал мэдэгдэхүйц сайжирсан.

Хэрэглэгчдийн худалдан авах зардлыг бууруулах зорилгоор 2026 оны эхний улиралд АНУ-аас тээвэрлэгдэх ачааны хүргэлтийн үнийг 20 хувиар бууруулж, БНХАУ-аас ирэх барааны тээврийг үнэ төлбөргүй хэвээр хадгалсан. Ингэснээр хэрэглэгчид өргөн сонголттой барааг илүү хэмнэлттэй нөхцөлөөр захиалах боломжийг үргэлжлүүлэн бүрдүүлэв.

Мөн 12 Стора боксын багтаамжийг нэмэгдүүлснээр том оврын барааг Стора агуулахад очих шаардлагагүйгээр өөрт ойр байрлах СУ салбараас хүлээн авах боломжтой болсон нь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хэрэглэгчдийн цаг хугацаа, зардлыг хэмнэхэд дэмжлэг үзүүлэв.



НЭГТГЭСЭН ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТОВЧ ТАЙЛАН

/Сая төгрөгөөр/	2024 оны 6-р сарын 30	2024 оны 12-р сарын 31	2025 оны 6-р сарын 30	2025 оны 12-р сарын 31	2026 оны 6-р сарын 30
Нийт цэвэр борлуулалт	263,631.9	334,746.8	362,080.0	434,337.0	430,750.4
Борлуулалтын өртөг	217,619.7	270,233.2	293,782.1	354,788.9	350,024.6
Нийт ашиг (алдагдал)	46,012.2	64,513.6	68,297.9	79,548.1	80,725.8
Нийт ашгийн хувь	17.5%	19.3%	18.9%	18.3%	18.7%
Үйл ажиллагааны зардал	10,473.5	19,003.2	19,775.6	35,738.4	26,926.3
ХТЭХӨАшиг	35,538.7	45,510.4	48,522.3	43,809.7	53,799.5
ХТЭХӨАшгийн хувь	13.5%	13.6%	13.4%	10.1%	12.5%
Элэгдэл хорогдол	16,023.9	16,874.4	21,066.6	24,627.4	28,866.9
Мөнгөн бус зүйлс - олз (гарз)	1,461.8	701.6	(399.9)	3,232.9	(380.9)
ХТӨАшиг	20,976.5	29,337.5	27,055.8	22,415.2	24,551.6
Санхүүжилтийн зардал	9,746.0	9,692.2	10,282.1	13,459.9	16,570.4
Татварын өмнөх ашиг (алдагдал)	11,230.5	19,645.3	16,773.7	8,955.3	7,981.2
Татварын өгөөж (зардал)	578.0	2,372.0	1,055.4	(2,490.4)	1,291.5
Цэвэр ашиг (алдагдал)	10,652.5	17,273.3	15,718.3	11,445.7	6,689.8
Цэвэр ашгийн (алдагдлын) хувь	4.0%	5.2%	4.3%	2.6%	1.6%

Тайлбар: (1) Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт
(2) Харьцуулалт хийх зорилгоор 2024 оны 2-р хагас жилийн дүн дээр Бизнес нэгдлээс үүссэн нэг удаагийн 19.4 тэрбум төгрөгийн олз цэвэрлэж харуулсан болно.

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН


/Сая төгрөгөөр/	2024 оны 6-р сарын 30 /аудитлагдаагүй/	2024 оны 12-р сарын 31 /аудитлагдсан/	2025 оны 6-р сарын 30 /аудитлагдаагүй/	2025 оны 12-р сарын 31 /аудитлагдсан/	2026 оны 6-р сарын 30 /аудитлагдаагүй/
Эргэлтийн хөрөнгө	58,096.8	78,429.0	101,717.9	116,044.0	132,978.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,088.5	10,431.5	5,825.8	21,732.9	20,425.0
Дансны авлага	3,382.6	6,042.3	11,266.4	10,320.0	19,107.1
Бараа материал	34,354.2	47,194.5	60,397.5	67,459.5	64,346.2
Бусад эргэлтийн хөрөнгө	13,271.5	14,760.7	24,228.2	16,532.0	29,099.7
Эргэлтийн бус хөрөнгө	186,151.1	216,025.8	256,602.3	322,289.0	354,098.1
Биет болон биет бус хөрөнгө	114,667.5	138,430.9	170,375.1	229,177.0	229,520.6
Ашиглах эрхтэй хөрөнгө	51,367.7	60,568.6	69,890.9	79,127.3	84,800.0
Бусад эргэлтийн бус хөрөнгө	20,115.9	17,026.3	16,336.3	13,985.0	39,777.4
НИЙТ ХӨРӨНГӨ	244,247.9	294,454.8	358,320.2	438,333.0	487,076.1
Богино хугацаат өр төлбөр	84,272.1	116,262.5	140,507.8	166,442.0	220,374.0
Дансны өглөг	50,332.3	56,829.4	82,394.1	73,046.0	114,177.9
Богино хугацаат зээл	12,740.8	25,360.3	19,157.5	41,508.0	69,579.0
Бусад богино хугацаат өр төлбөр	21,199.0	34,072.8	38,956.2	51,888.0	36,617.0
Урт хугацаат өр төлбөр	98,607.7	94,880.2	118,782.0	157,664.0	152,655.5
Урт хугацаат зээл	31,072.3	23,868.3	31,058.4	79,300.0	69,898.6
Бусад урт хугацаат өр төлбөр	67,535.4	71,011.9	87,723.6	78,364.0	82,756.9
Эздийн өмч	61,368.1	83,312.1	99,030.4	114,227.0	114,046.6
Энгийн хувьцаа	111,425.2	111,425.2	111,425.2	111,425.0	111,425.2
Халаасны хувьцаа	-	-	45,757.9	(5,050.0)	-
Нэмж төлөгдсөн капитал	45,757.9	45,757.9	318.7	33,134.0	20,637.0
Эздийн өмчийн бусад хэсэг	318.7	318.7	9,492.9	319.0	318.7
Хяналтын бус хувь оролцоо	3,398.5	8,873.4	-	17,116.0	18,466.3
Хуримтлагдсан ашиг	(99,532.2)	(83,063.1)	(67,964.3)	(42,717.0)	(36,800.6)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	244,247.9	294,454.8	358,320.2	438,333.0	487,076.1

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН


/Сая төгрөгөөр/	2024 оны 6-р сарын 30	2024 оны 12-р сарын 31	2025 оны 6-р сарын 30	2025 оны 12-р сарын 31	2026 оны 6-р сарын 30
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	302,153.8	396,146.9	415,938.3	476,511.7	496,073.6
Мөнгөн зарлагын дүн (-)	(278,977.5)	(366,962.0)	(365,110.4)	(455,467.6)	(437,763.8)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	23,176.3	29,184.9	50,827.9	21,044.1	58,309.8
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	1,445.1	3,984.0	819.4	(383.4)	1,767.9
Мөнгөн зарлагын дүн (-)	(10,342.3)	(25,992.3)	(43,623.0)	(49,409.0)	(52,205.4)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,897.2)	(22,008.3)	(42,803.7)	(49,792.4)	(50,437.5)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	30,891.3	34,847.5	252,738.4	331,859.6	244,691.2
Мөнгөн зарлагын дүн (-)	(40,990.9)	(38,621.4)	(265,299.5)	(287,115.5)	(253,758.9)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10,099.6)	(3,773.9)	(12,561.1)	44,744.1	(9,067.7)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн зөрүү	(71.6)	(59.7)	(68.8)	(89.2)	(111.5)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,107.9	3,343.0	(4,605.8)	15,906.6	(1,306.9)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,980.6	7,088.5	10,431.5	5,825.8	21,732.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,088.5	10,431.5	5,825.8	21,732.4	20,425.5

САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Борлуулалтын орлого, тэрбум ₮




Цэвэр ашиг, тэрбум ₮




Нийт хөрөнгө, тэрбум ₮




Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ, тэрбум ₮



Борлуулалтын орлого



Цэвэр ашиг



Хувьцааны ханшийн хөдөлгөөн

ПРЕМИУМ НЭКСУС ХК (CUMN):

2026 оны 6-р сарын 30-ний өдрийн байдлаар:

₮265.71

Нээлтийн ханш: 270


Нийт гаргасан хувьцаа: 1,114,252,034


Хаалтын ханш: 265.71

Эргэлтэд гаргасан хувьцаа: 1,114,252,034

52 долоо хоног: 185.00 - 335.00

Зах зээлийн үнэлгээ: 296,067,907,954.14





Анхаарал
хандуулсанд
баярлалаа

Холбоо барих:

И-мэйл: investor@cumongol.mn